NEW ERA
international school

12-Р АНГИ НИЙГЭМ СУДЛАЛ

ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ

10-Р АНГИ
БУЛЭГ СЭДЭВ
СОЁЛ

ХИЧЭЭЛИЙН СЭДВҮҮД

СОЁЛ ГЭЖ ЮУ ВЭ?

СОЁЛЫГ БҮРҮҮЛЭГЧ ЭЛЭЕМЕНТҮҮД

МОНГОЛ СОЁЛЫН НЭГДМЭЛ ШИНЖ

СОЁЛЫН ТҮГЭЭМЭЛ ШИНЖ

СОЁЛЫГ ХЭРХЭН АНГИЛЖ БОЛОХ ВЭ?

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

ТУЛГУУР ОЙЛГОЛТ

ГОЛ ТӨЛӨӨЛӨГЧИД

ТОДОРХОЙЛОЛТ

ТЕСТ

СОЁЛ ГЭЖ ЮУ ВЭ?

СОЁЛ НЬ ДАРААХ ОНЦЛОГ ШИНЖТЭЙ. ҮҮНД:

- ✓ Соёл бүтээх болон эзэмших явдал бол ид шидийн хүчний илрэл биш, харин хүмүүс хамтын амьдралынхаа явцад тодорхой хэрэгцээний дагуу бүтээдэг.
- ✓ Соёл нь хүний амьдралын бүх талыг хамарсан өргөн хүрээтэй үзэгдэл юм. Хүн бол соёлын бүтээгдэхүүн.

Соёл (culture) гэдэг үг colere гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд “соёолон боловсруулах, хөрс боловсруулах” гэсэн утгатай. Энэ ойлголт хөгжсөөр оюуны болон материаллаг үнэт зүйлсийг тэмдэглэх утгатай болжээ.

АМЕРИКИЙН СОЦИОЛОГИЧ А. ГИДДЕНС

“Тодорхой бүлгийн гишүүдэд байдаг үнэт зүйлс, тэдгээрийг дагаж мөрддөг хэм хэмжээ болон материаллаг баялгийг багтаадаг цогц ойлголтыг соёл гэнэ”.

НИЙГЭМ СОЁЛЫН АНТРОПОЛОГИЧ Р. БЕНЕДИКТ

“Зөгий, шоргоолжны эд эсэнд нь шингэсэн үйлдэл хийх чадвар байдаг шиг хүнд төрөлхөөс заяадаггүй, ахмад үеэсээ залуу үе нь зориуд сурч мэдэх, өвлөх ёстой үйлдэл хийх чадвар байдгийг **СОЁЛ** гэж тэмдэглэдэг”.



БРИТАНИЙН УГСААТНЫ ЗҮЙЧ ЭДУАРД ТАЙЛОР

“**СОЁЛ** нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшсэн мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар дадлуудыг багтаасан цогц бүхэл юм”.

Германы философич

Эрнст Кассирер

Соёл бол янз бүрийн бэлгэ тэмдгүүдийн (хэл, бичгийн хэл, урлаг, шинжлэх ухаан гэх мэт) нэгдэл мөн.

ЮНЕСКО, 2001

СОЁЛ гэдэг нь нийгэм болон нийгмийн хэсэг бүлгийн оюун санаа, материаллаг байдал, мэдлэг, оюун сэтгэл санааны шинж байдлын цогц мөн. Соёл нь урлаг утга зохиол төдийгүй амьдралын хэв маяг, хамтын амьдралын арга зам, үнэ цэнтэй систем, уламжлал, итгэл үнэмшлийг хамаарна.

Соёлыг бүрдүүлэгч элементүүд

БЭЛГЭ ТЭМДЭГ

Соёлын үзэгдлүүд тэмдгэн хэлбэрээр оршдог.

ХЭЛ

Тэмдгийн хамгийн түгээмэл хэлбэр

ҮНЭЛЭМЖ

Юуг зөв, юуг буруу гэж үзэх нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэ чанар

ХЭМ ХЭМЖЭЭ

Хүмүүсийн зан төлөвийг зохицуулдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил

МЭДЛЭГ

Хүмүүсийн мэддэг баримт, туршлага, үнэт зүйлсийг хэлнэ.

Германы философич

Эрнст Кассирер

Хүн бол бэлгэдэл бүтээгч амьтан. Иймд хүн бол байгалийн ертөнцийн төдийгүй бэлгэдлийн ертөнцөд амьдардаг. Энэ бол домог, хэл, урлаг, шашин, түүх, шинжлэх ухааны ертөнц байх юм.

Соёлыг бүрдүүлэгч элементүүд

- Хэл бол тэмдгийн тогтолцоо мөн. ТӨРӨЛХ ХЭЛ, ЗОХИОМОЛ ХЭЛ
  - Тухайн үндэстэн угсаатныг нэгтгэж, нийгэм болгож байгаа гол шинж юм.
  - Соёлыг нэг үеэс нөгөө үед дамжуулах, соёлыг бүтээх, илтгэх арга хэрэгсэл мөн.

Соёлыг бүрдүүлэгч элементүүд

Соёлыг бүрдүүлэгч элементүүд

ОЙЛГОЛТ	УТГА САНАА	ТАЙЛБАР
ҮНЭЛЭМЖ	Нийт хүн төрөлтний хувьд хүлээн зөвшөөрөгдсөн утгат чанарууд	Сайн үйл, шударга ёс, эрх чөлөөг аль чард түмэн эрхэмлэдэг.
ҮНЭЛЭМЖИЙН БАРИМЖАА	Үнэлэмжийг хувь хүн өөриймжүүлсэн хэм хэмжээ	Хүмүүс үзэл санаа, итгэл үнэмшил, ёс суртахууны хувьд харилцан адилгүй сонголт хийдэг.
ҮНЭЛГЭЭ	Нийгмийн бүлэг, хамт олон, бие хүний зан төлөв, үйлдлийг тодорхой шалгуурт нийцэж байна уу, үгүй юу гэдгийг шүүн тунгаах үйл явц	Бид аливаа үйл явдал, үзэл санааг дэмжих, буруутгах, шүүмжлэх, магтах зэргээр янз бүрээр үнэлж, дүгнэж байдаг.

Соёлыг бүрдүүлэгч элементүүд

СОЁЛЫН ЧИГ ҮҮРЭГ	ТАЙЛБАР
БЭЛГЭДЛИЙН ЧИГ ҮҮРЭГ	СОЁЛЫН ҮЗЭГДЛҮҮД ТЭМДГЭН ХЭЛБЭРЭЭР ОРШДОГ. ТЭМДГИЙН ХАМГИЙН ТҮГЭЭМЭЛ ХЭЛБЭР НЬ ХЭЛ ЮМ.
ҮНЭЛЭМЖ, ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ЧИГ ҮҮРЭГ	НИЙГЭМД ҮЙЛЧИЛЖ БАЙДАГ ХЭМ ХЭМЖЭЭГ ЭЗЭМШСЭНЭЭР ХҮМҮҮС АМЬДРАЛЫН ЧИГ БАРИМЖААГАА ОЛЖ АВДАГ
НЭГТГЭН ЗОХИЦУУЛАХ ЧИГ ҮҮРЭГ	СОЁЛ НЬ НИЙТЛЭГ ИТГЭЛ ҮНЭМШИЛ, ҮНЭЛЭМЖИЙН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ ЗАМААР НИЙГМИЙГ НЭГТГЭДЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ	ӨМНӨХ ҮЕИЙН БҮТЭЭСЭН НИЙГЭМ-СОЁЛЫН УЛАМЖЛАЛЫГ ӨВЛҮҮЛЭХ НЬ НИЙГМИЙН ОРШИХУЙН ҮНДЭС ЮМ.

Монгол соёлын нэгдмэл шинж

Угсаатан

- Түүх, соёл, амьдрал ахуйн хувьд бие биетэйгээ ойр төрөл, нэгэн угсаа гаралтай хүмүүсийг хэлдэг.

Үндэсний соёл

- Тухайн улс үндэсний нийтийн хүртээл болсон итгэл үнэмшил, зан байдлын хэв маяг, үнэлэмж болон институтуудын нэгдлийг илэрхийлдэг.

Ястан

- Нийтлэг аялга, зан заншил, сэтгэл зүй, аж ахуй, нутаг дэвсгэр бүхий овгуудын нэгдэл юм.

Монгол соёлын нэгдмэл шинж

Зонхилогч соёл

Тухайн нийгмийн гишүүдийн дийлэнхэд нь зонхилж буй амьдрах зан үйл, үйлдлийн загварыг тодорхойлогч соёл

Дэд соёл

Зонхилогч соёлоос бага зэргийн ялгаатай боловч түүнтэй нийцэж байдаг соёл.

Соёлын түгээмэл шинж

Дэлхий нийтийн олон янзын соёлд нийтлэг, ерөнхий шинж ажиглагддаг бөгөөд энэ байдлыг соёл судлалд **“СОЁЛЫН ТҮГЭЭМЭЛ ШИНЖ”** гэсэн ойлголтоор илэрхийлдэг.

Соёлын түгээмэл шинж нь дараах зүйлээр илэрдэг. Үүнд:

- Үндэстэн бүр өөр өөрийн хэлтэй.
- Бэлгэдэл
- Нийтлэг үнэлэмж
- Үндэстэн бүрийн соёлд газарзүйн байрлал, уур амьсгал, эрхлэх аж ахуй нөлөөлдөг.
- Зан үйл, сүсэг, ёс заншил

Жорж Мердок (1897-1985)

Аль ч ард түмний түүх, соёл, угсаатны зүйд хөдөлмөрийн зэвсэг бүтээх, биеэ гоёх, цус холилдохыг хориглох, бүжиг, спорт, шашны зан үйл, бэлэг өгөх, зочлох, оршуулах ёс заншил, хэл, боловсрол зэрэг 72 төрлийн түгээмэл шинж илэрдэг байна.

Соёлыг хэрхэн ангилж болох вэ?

СОЁЛЫН ТҮВШИН

Улс үндэсний соёл

- Монгол орон бол эртний соёлт орон
- Дорнын соёлын хүрээ
- Буддын соёлт орон г.м.

Олон улсын соёл

- Даяаршил
- Соёлын харилцаа
- Нийтлэг

Нэг хэв загвар/Олон хэв загвар